



**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Хөрөнгө захиран зарцуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2. дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр тохиож буйтай холбогдуулан Захиргаа, удирдлагын хэлтсээс гаргасан судалгааны үндсэн дээр тус үйлдвэрийн газрын ажиллагсдын 0-17 насны хүүхдүүдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээнд шаардагдах 957,000 /Есөн зуун тавин долоон мянга/-н төгрөгийг байгууллагын холбогдох зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дүүриймаа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Д.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ц.ЦЭРЭН

000069